

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ГАРААНЫ ҮНЭЛГЭЭ МОНГОЛ ХЭЛ Хувилбар В

Нэгдүгээр хэсэг

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 40 сонгох даалгавартай. Нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. 1-14 дүгээр сорилыг эхийн утга санаатай холбон ажиллаарай. Зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

Миний тоонот

Алга дарам газраас эх орон эхэлдэг гэж би боддог. Учир нь энэхэн зайд эхийн алтан хэвлийгээс хүй тасран унасан билээ. Эхээс унасан газрыг "тоонот", хүй дарсан чулууг "хүйс" гэж нэрлэдэг. Миний тоонот газар хэзээд санаанд санаатай, бодолд уяатай. Тоонот минь үлгэрийн сайхан диваажин шиг биш ч гэлээ, төрж өссөн унаган нутаг болохоор уул ус, ургамал цэцэг, ан амьтад нь сэтгэлд ойр, ертөнцөд хаана ч байхгүй, сайхнаас сайхан, гоёос гоёхон билээ.

Хээрийн хонгор салхинд өнгө өнгийн өвс ногоо найган ганхсан, далан хэлийн шувууд дуу дуугаа авалцан жиргэсэн тийм нэг сайхан намрын өглөө би Уртын голын дэнж дээр эхээс мэндэлсэн юм. Намайг төрөхөд олондоо нэр хүндтэй хүнээр эх бариулна хэмээн урьдаас дуулган ирүүлсэн Лэгээ гуай бол миний хүйг боосон "хүйс ээж", "авсан ээж", "эх барьсан ээж", "газар ээж", "боосон ээж", "хуурайлсан ээж", "өрлөг ээж" минь билээ. Хүйг минь дарсан хүрэн бор эр чулуу эдүгээ ч байрандаа намайг хүлээдэг. Жил бүр нутагтаа очиж, хүй дарсан газраа хөрвөөн, цэцгийн үнэрт агаараар цээжээ уужиртал амьсгалж, ариун булгийнхаа рашаанаас хүртэж, сэрүүн дэнж дээгүүрээ хөл нүцгэн алхахад энэ жилийн ядаргаа тайлагдан, ирэх жилийн ажлын эрч хүч авдаг сан.

Хүн бүхэн эхээс унасан тохмын чинээхэн тоонот газартаа хөлд орж, эндээс эхэлж мөрөө гаргадаг. Орчлонг тойрч, дэлхийг хэрэн хэсэхдээ тоонот газартайгаа аргамжаатай явдаг юм. Алс нутгаар аялан явах бүрийд агуу их улс орны дэргэд миний төрсөн хязгаар нутаг, сэрүүн булгийн дэнж минь дэндүү бага болохыг улам бүр мэдэрдэг. Гэвч миний тоонот дэнж надад улам үнэ цэнтэй, ойр дотно санагдаж, хаа холын газраас эргэж очихын хүслэн төдий чинээ төрдөг юм. Тоонот газар, эх орноо хайрлахад **хараа цуцам цэлгэр хөндий, хязгаар хярхаггүй цэлийм их тал эсвэл тэнгэр тулам өндөр уул, тэнгис далайн их ус, ургамал цэцэг тэгширсэн баян бүрд байх албагүй билээ.** Эх орноо хайрлах хайр төрсөн нутаг тоонот газар, хүй дарсан жижиг чулуугаа санан дурсах сэтгэлээс, эхийн бүүвэйн дуунаас, анх хэлсэн үгээс, зулайг минь үлээсэн сэвшээ зөөлөн салхинаас, ууж умдаалсан булгийн хоржигнох чимээнээс ирж шингэдэг.

Эх орон, эх нутаг, тоонот газар гэдэг хүнд аав ээж шиг ганц л заяадаг. Алтнаас үнэтэй, аминаас эрхэм зүйл гэж байдаг бол надад тэр нь тохмын чинээхэн тоонот газар минь билээ.

Д. Баттогтох

1. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | | |
|-------------------|--|-------------------|
| 1. тохом | a. хэмжээ төгсгөлгүй | |
| 2. аргамжаа | b. нам дор газраас өндөрлөг тэгшдүү газар | |
| 3. дэнж | c. эмээлийн доор жийрэглэсэн эсгий зөөлөвч | |
| 4. хярхаггүй | d. морь малыг аргамжих урт сур, дээс, олс | |
| A. 1c, 2d, 3b, 4a | B. 1c, 2d, 3a, 4b | C. 1d, 2c, 3a, 4b |
| D. 1a, 2d, 3c, 4b | E. 1b, 2d, 3a, 4c | |

2. Бүгд хүндэтгэлийн үг бүхий хэсгийг сонгоно уу.

- A. орчлон, тоонот, сэвшээ
- B. хүй, дэнж, эрч хүч
- C. алтан хэвлий, тоонот, хүртэх
- D. мэндлэх, Лэгээ гуай, үнэр
- E. алтан хэвлий, хүртэх, хайрлах

3. Ойролцоо утгатай хэлц бүхий хэсгийг сонгоорой.

- A. хараа цуцам - тохмын чинээ
- B. алга дарам - далан хэлийн
- C. аргамжаатай явах - хэрэн хэсэх
- D. хараа цуцам - хязгаар хярхаггүй
- E. хүй дарах - алтан хэвлий

4. Эхийн агуулгын уялдааг үйлээр зөв дараалуулсныг олоорой.

- A. унасан, санагдсан, эх барьсан, заяасан
- B. гоё, хүрэн бор, жижиг, тохмын чинээ
- C. заяасан, умдаалсан, хүртсэн, унасан
- D. хүйс, эрч хүч, хайр, үнэ цэн
- E. бодсон, хүлээсэн, мэдэрсэн, заяасан

5. Эхийн сэдвийг сонгоно уу.

- A. Шинэ нутгаар аялан явдаг тухай
- B. Алга дарам газраас эх орон эхэлдэг тухай
- C. Төрж өссөн Уртын голын тухай
- D. Эх барьсан ээжийн тухай
- E. Ариун булгийн рашаанаас хүртсэн тухай

6. Цогцолборуудын гол санааг түлхүүр үгээр зөв хураасныг олоорой.

- A. алтан хэвлий - сэрүүн дэнж - хязгаар нутаг - аав ээж
- B. тоонот газар - хүй дарсан чулуу - төрсөн нутаг - эх орон
- C. үлгэрийн диваажин - Лэгээ гуай - улс орон - эрхэм зүйл
- D. ургамал цэцэг - намрын өглөө - миний тоонот - эх нутаг
- E. ан амьтад - боосон ээж - орчлон дэлхий - тохмын чинээ тоонот

7. "Зохиогчийн төрсөн газар орон, цаг хугацаа"-г мэдээлсэн баримт нь аль вэ?

- A. Түүний төрсөн газар нь хязгаар нутаг, сэрүүн булгийн дэнж юм.
- B. Намрын нэгэн өглөө Уртын гол гэдэг газар хүй тасарсан.
- C. Лэгээ гуай бол түүний "эх барьсан ээж", "хуурайлсан ээж" нь ажээ.
- D. Эхээс унасан газрыг "тоонот", хүй дарсан чулууг "хүйс" гэж нэрлэдэг.
- E. Сэтгэлд ойр, сайхнаас сайхан, гоёхноос гоёхон нутагтай билээ.

8. Эхийн онцолсон хэсэгт тоочимжийн ямар онцлог шинж байна вэ?

- A. Юмс үзэгдлийг харьцуулан жишиж тайлбарласан.
- B. Үйл явдлыг нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрсэлсэн.
- C. Юмс үзэгдлийн уялдаа холбоог тайлбарласан.
- D. Юмс үзэгдлийг нэгэн орон зайд тоочин дүрсэлсэн.
- E. Хэрэг явдлыг дарааллаар өрнүүлэн дүрсэлсэн.

9. Зохиогчийн үнэлэмжийг олоорой.
- A. Сэрүүн булгийн дэнж минь дэндүү бага болохыг улам бүр мэдэрдэг.
 B. Би Уртын голын дэнж дээр эхээс мэндэлсэн юм.
 C. Энэ жилийн ядаргаа тайлагдан, ирэх жилийн ажлын эрч хүч авдаг
 D. Миний тоонот газар хэзээд санаанд санаатай, бодолд уяатай.
 E. Ертөнцөд хаана ч байхгүй, сайхнаас сайхан, гоёос гоёхон нутаг билээ.
10. Үнэрлэх, амтлах, харах мэдрэмжийг илэрхийлсэн уран дүрслэлийг сонгоно уу.
- A. цэцгийн үнэрт агаар, ариун рашаанаас хүртэх, хараа цуцам цэлгэр хөндий
 B. булгийн ус хоржигнох, хөл нүцгэн алхах, тохмын чинээ газар
 C. шувуу адил нисэх, цээж дүүрэн амьсгалах, эрч хүч авах
 D. далан хэлийн шувуу жиргэх, хүй тасран унах, алтнаас үнэтэй нутаг
 E. хүй дарсан газраа хөрвөөх, үлгэрийн сайхан диваажин, санан дурсах сэтгэл
11. "Алс шинэ нутгаар аялан явах" гэсэн өгүүлбэрт онцолсон үгийг "гуйранчлан" хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?
- A. Доод найруулгын зэрэгтэй болно. B. Хүндэтгэлийн утгатай болно.
 C. Найруулгад өөрчлөлт орохгүй. D. Дээд найруулгын зэрэг хэвээр.
 E. Найруулгын ерийн зэрэгтэй болно.
12. Онцолсон гишүүн өгүүлбэрийн утгын уялдааг тодорхойлоорой.
 Хүн бүхэн **эхээс унасан** тохмын чинээхэн тоонот газартаа хөлд ордог.
- A. "тоонот" гэснийг шалтгааны утгаар дэлгэрүүлсэн
 B. "хөлд ордог" гэснийг цагийн утгаар дэлгэрүүлсэн
 C. "тохмын чинээ" гэснийг шинж чанарын утгаар дэлгэрүүлсэн
 D. "хүн бүхэн" гэснийг зорилгын утгаар дэлгэрүүлсэн
 E. "газартаа" гэснийг тодотгож, дэлгэрүүлсэн
13. "Ариун булгийн рашаанаас хүртэх" гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
- A. Булгийн рашаанаас хүртэх
 B. Рашаанаас хүртэх
 C. Ариун булгийн цэнгэг рашаанаас хүртэх
 D. Булгийн ариун рашаанаас хүртэх
 E. Ариун булгийн рашаанаас уух
14. "Хүй дарсан газраа очиж хөрвөөдөг"-ийн учир юу вэ?
- A. Тоонот газар, эх орноо хайрлах
 B. Хөлд орж мөрөө гаргасан газраа эргэх
 C. Ядаргаагаа тайлж, эрч хүч авах
 D. Аав, ээжийнхээ нутгийг эргэх
 E. Хоржигносон булгаасаа ууж ундаалах
15. Найруулгын алдаатай өгүүлбэрийг сонгоорой.
- A. Оюутнууд аа, эхнээсээ л хичээх хэрэгтэй.
 B. Тандаа эх үрсийн баярын мэнд хүргэе!
 C. Биднүүсийн яриа бага ангийнханд ихэд таалагдав.
 D. Манай гэр бүл Увс нуур хүртэл аяллаа.
 E. Интернэт орчинд соёлтой харилцъя.
16. Холбоо үгсийн бүтсэн аргын зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг олно уу.
 эрэл сурал, цанын бааз, уншиж бичих,
- A. өгсөж уруудах B. хөхөө шувуу C. эрт урьд
 D. ойн чөлөө E. дуу хөгжим
17. Далимдах утгат бүтээврийг сонгоорой.
- A. -нгаа B. -хлаар C. -вч D. -нгуут E. -магц
18. Нутгийн аялгууны үгийг олоорой.
- A. интернэт B. тоохуу C. зах зээл D. банш E. ЮНЕСКО
19. "Тариаланчид буудайгаа хурааж, малчид өвөлжөө рүүгээ нүүцгээнэ" гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийг солин найруулахад аль нь тохирох вэ?
- A. -вч B. -н C. -магц D. -тал E. -х
20. Тайлбарыг жишээтэй зөв харгалзуулсныг сонгоно уу.
1. туул а. эцэс хязгаар
 2. тууль б. ус гол гатал
 3. туйл в. аман зохиол
- A. 1а, 2б, 3с B. 1а, 2с, 3б C. 1с, 2а, 3б
 D. 1б, 2с, 3а E. 1б, 2а, 3с
21. Эсрэг утгат бүтээвэр бүхий хэсгийг олоорой.
- A. ач + тан, ач + тай B. барь + л, барь + аач C. ов + ой, ов + н
 D. уйл + хай, уйл + нхай E. илч + тэй, илч + гүй
22. "Гагнасан гинжийг таслагтун" өгүүлбэрийн онцолсон үгийн язгуурыг олоорой.
- A. гагна B. ган C. ганна D. гаг E. гагнуур
23. Залгавар залгахад "ь" нь "и" болох үгийг олно уу.
- A. тарь+даг B. тань + ж C. урь + я
 D. дохь + цгоо E. горьгүй
24. Дараах өгүүлбэрт таслал хэрэглэсэн шалтгааныг сонгоорой.
 Түүний онигор нүд, монхор хамар, урт туушин, уужим магнай, навчин чих, нарийн бүсэлхий, түхгэр цээж, урт гар, өргөн аарцаг, уудам салтаа, том тавхай нь яах аргагүй сайн бөхийн арван шинж бүрдсэний гэрч ажээ.
- A. Тоочсон олон зүйлсийг утгаар зүйлчлэн ялгасан тул
 B. Нийлмэл өгүүлбэр тул
 C. Оруулсан үг тул
 D. Санаа бүрэн төгсөөгүй тул
 E. Тоочсон үгсийн хооронд тул



35. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- | | | | | |
|-------|------|-------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| هتتتت | هتتت | هتتتت | هتتت | هتتت |

36. "Би" гэсэн үгийг эзэнд хамаатуулах нөхцөлтэй өгөх оршихын тийн ялгалаар хувилгасан нь аль вэ?

- | | | | | |
|-----|-----|-----|-----|-----|
| A. | B. | C. | D. | E. |
| هتت | هتت | هتت | هتت | هتت |
| هتت | هتت | هتت | هتت | هتت |

37. Бүрмөсөн үйлдэх байдлын -чих дагаврыг сонгоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| هت | هت | هت | هت | هت |

38. "унш" гэсэн үгийг биеэр төгсгөвөл аль нөхцөлийг залгах вэ?

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| هت | هت | هت | هت | هت |

39. "зар бичиг, зарцалж зар"-ыг утга ялгасан хэсгийг олгоорой.

- | | | | | |
|----|----|----|----|----|
| A. | B. | C. | D. | E. |
| هت | هت | هت | هت | هت |

40. Зөвийг сонгоно уу.

- | | | | | | |
|----|----------------|------------|---------------|-------------|-------------|
| هت | A. Лихтенштейн | B. либерал | C. лаборатори | D. лаборант | E. логарифм |
|----|----------------|------------|---------------|-------------|-------------|

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

Жич: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------|--|
| a. Мөс хагарав. | 1. үйлийн тодотгол гишүүнтэй цөм бус өгүүлбэр |
| b. Ах морь уналаа. | 2. байц гишүүнтэй цөм бус өгүүлбэр |
| c. Ширээний хөл догонцов. | 3. харьяалахын тодотгол гишүүнтэй цөм бус өгүүлбэр |
| d. Сайн явж ирсэн. | 4. хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| e. Гадуур зугаална. | 5. гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |

2.2. Холбох үг, нөхцөлийг харгалзуулна уу.

- | | |
|-----------|--|
| a. улмаас | 1. цагийн утгат угсруулан холбох үг |
| b. агаад | 2. угсруулан холбох нөхцөл |
| c. -төл | 3. зэрэгцүүлэн холбох нөхцөл |
| d. -ж | 4. зэрэгцүүлэн холбох үг |
| e. турш | 5. шалтгааны утгат угсруулан холбох үг |

2.3. Бүтээврийн нийлцийг тохирох дүрэмд харгалзуулаарай.

- | | |
|------------------|---|
| a. хүрсэн + ээр | 1. Ялгах үүрэгтэй эгшгийг гээхгүй. |
| b. нугалбар + ыг | 2. Зөөлрүүлэх үүрэгтэй эгшгийг гээхгүй. |
| c. цочтол + оо | 3. Эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй. |
| d. чанар + ын | 4. Заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй. |
| e. сахил + аар | 5. Балархай эгшиг үүрэггүй болсон тул гээгээ. |

2.4. Үгсийг тохирох утгатай нь харгалзуулна уу.

- | | | | | | |
|------------------|----|----|----|----|----|
| a. таар /уулзах/ | 1. | 2. | 3. | 4. | 5. |
| b. тээр /дараас/ | هت | هت | هت | هت | هت |
| c. дайр /үйл үг/ | | | | | |
| d. таар /шуудай/ | | | | | |
| e. дээр /доор/ | | | | | |

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

ГАРААНЫ ҮНЭЛГЭЭ МОНГОЛ ХЭЛ Хувилбар С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 40 сонгох даалгавартай. Нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. 1-14 дүгээр сорилгыг эхийн утга санаатай холбон ажиллаарай. Зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

Хошуу цагаан нутаг санагдах янзтай

Хошуу цагаан нутгаасаа хол явна даа, хүү чинь. Үүл нүүсэн мөнх хөх тэнгэрийн доогуур шувуу адил нисээд, шуурга болж туйлаад ч хүрэхээргүй холын газар байна. Алсын уулын оройд агаарын будан манантаж, ойрын уулын хормойд огторгуйн будан хөглөрсөн уймраа мянганы газраас ус нутгаа санах гэдэг ухаант хүмүүнд байтугай нутаг хошуу алгассан адуу малд ч байдаг эхийгээ тэмцсэн үрийн төрөлх араншин сэтгэл дотор тонгочно.

Хээлэндээ очсон унага салхи нөмөрсөн цагтаа ус нутагтаа гүйдэг гэсэн домог шахуу үнэнийг дорнын их талд санаж л явна, би. Хээрийн галуу шиг зоргоор хүний үр намайг энд алтан аягаар рашаан зооглуулж, мөнгөн царанд идээ таваглалаа ч хоног хоногоор хоргоох гэж зовох янзтай. Аяс намуун талын алиа гэнэхэн салхи хөлийн доор томолдож, амраг нэгний санаашрал сонор шүргээд буцахад алс замын бодол Алтай, Хангайдаа хулжаад, рашаан тунгалаг Туулаа аргагүй санаж цангах юм. Долоон бурхан одондоо долоон шөнөө манууллаа, дорнын буурал сарыг долоон шөнө сэрээлээ, Гэвч явдал замын надад яарч буцах гэр минь байна, явган нүцгэн ч гэлээ очоод жаргах оромж минь хүлээнэ.

Хүний газрын шуугианд чих дөжирч явахдаа өөрийн нутгийн заримтай мэнд сольж амжлаа. Бидний цөөхөн монголчууд яргуй хөөсөн ямаа шиг бэлэн тангсийг эрээд, хорвоогоор тарчихсан юм уу даа. Мөр зүгээрээ яваа бол миний дүү нар сайн сан. Гэтэл ойворгон зарим ухаантан, гэм тарьсан эх орны гэмгүй хөөрхий нэгэн шиг харийн хүний чихэнд унасан газар, угаасан усаа гоочлох нь юу сан. Өрөөлийн газар явахдаа худлаа ч гэсэн нутгаа магт гэх үг сургаал айлдам хөх амтай тийм хүмүүс хөлийн доор хөглөрөх нь ичиг. Атга будаа шүтэж, ам даавуунд хууртдаг алаг энэ хорвоод хүн чанараа гэж, хаана шургахаа мэдэхгүй, өсөж төрснөө мартах шахсан хүмүүний үрийг хараад, халаглаж өрөвдөх ч багадна. Адаглаад, агаар салхи нь эм алтан нутгаа магтдаггүй юмаа гэхэд үхэхийн цагт ясаа тавих алга дарам газар минь тэнгэрийн алс хаяанд бий гэж ухаанаа аргадаж, сэтгэлээ хуур, дүү минь. Чамд буян болно. Хошуу цагаан нутгаа санах л янзтай, холын цэнхэр нутагтаа өвгөн ах нь харьсугай.

Аяс намрын салхи нутаг зүгээс бөмбөрч, аян замын намайг дуудан хөтлөн байнам. Хээрийн цэцэгсээр энгэрээ гоёж, хөх буурал зэрэглээнд өдөржин бүүвэйлүүлж өнждөг нутаг зүгийн салхи намайг ч чамайг ч дууднам бус уу.

C. Пүрэв

1. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | |
|----------|---|
| 1. хошуу | a. орогнох байр, сууц |
| 2. хээл | b. ялтгар том таваг |
| 3. оромж | c. хуучны засаг захиргааны хуваарилалт |
| 4. цар | d. эм мал адгуусны хэвэл дотор тогтсон үр |

A. 1c, 2d, 3a, 4b
D. 1a, 2d, 3c, 4b

B. 1c, 2d, 3b, 4a
E. 1b, 2d, 3a, 4c

C. 1d, 2c, 3a, 4b

2. Бүгд хүндэтгэлийн үг бүхий хэсгийг сонгоно уу.

- A. араншин, сэтгэл, рашаан
- B. монголчууд, сонор, бурхан
- C. сонор, зооглох, айлдах
- D. оромж, дөжирч, гэм
- E. сонор, зооглох, буян

3. Ойролцоо утгатай хэлц бүхий хэсгийг олоорой.

- A. сэтгэл тонгочих - сэтгэлээ хуурах
- B. атга будаа - алга дарам газар
- C. явган нүцгэн - мөр зүг
- D. ухаанаа аргадах - ясаа тавих
- E. чих дөжрөх - шургахаа мэдэхгүй

4. Эхийн агуулгын уялдааг үйл үгээр зөв дараалуулсныг олно уу.

- A. тонгочих, хүлээх, дуудах, өрөвдөх
- B. өрөвдөх, тонгочих, хүлээх, дуудах
- C. дуудах, хүлээх, өрөвдөх, тонгочих
- D. тонгочих, хүлээх, өрөвдөх, дуудах
- E. аргадах, айлдах, хулжих, уймрах

5. Эхийн сэдвийг сонгоорой.

- A. Ойрын ууланд будан хөглөрдөг тухай
- B. Унасан газар, угаасан усаа гоочилдог тухай
- C. Ам даавуунд хууртдаг хүн чанарын тухай
- D. Явдал замын аянаас яарч буцах тухай
- E. Хүн амьтангүй л төрсөн нутгаа зорьдог тухай

6. Цогцолборуудын гол санааг түлхүүр үгээр зөв хураасныг олоорой.

- A. адуу мал - алс зам - харийн хүн - аян зам
- B. төрөлх араншин - жаргах оромж - угаасан ус - аяс намар
- C. будан манан - дорнын тал - үг сургаал - хээрийн цэцэг
- D. хошуу нутаг - буцах гэр - хүн чанар - нутаг зүг
- E. ус нутаг - долоон бурхан - хүмүүний үр - өнждөг нутаг

7. "Монголчууд яргуй хөөсөн ямаа шиг бэлэн тангсийг эрэн, хорвоогоор тарсан"-ыг аль баримт баталж байна вэ?

- A. Монгол хүн хээрийн галуу шиг зоргоор одох эрх чөлөөтэй.
- B. Атга будаа, ам даавуунд хууртаж яваа хүмүүстэй уулзаж учирсан.
- C. Унасан газар, угаасан усаа гоочилдгийг зохиолч сонссон.
- D. Алтан аягаар рашаан уух мэт харийн нутагт юм бүр байна.
- E. Алтан нутгаа магтдаггүй юмаа гэхэд үхэхийн цагт эргэн ирдэг.

8. Эхийн онцолсон хэсэгт эргэцүүлэмжийн ямар шинж байна вэ?

- A. Юмс үзэгдлийг харьцуулан жишиж тайлбарласан.
- B. Үйл явдлыг нэгэн цагт зэрэгцүүлэн тоочиж дүрсэлсэн.
- C. Юмс үзэгдлийн уялдаа холбоог тайлбарласан.
- D. Хэрэг явдлаас үүдэлтэй бодомж дүгнэлт гаргасан.
- E. Хэрэг явдлыг дарааллаар өрнүүлэн дүрсэлсэн.



9. "Долоон бурхан одондоо долоон шөнөө манууллаа, дорнын буурал сарыг долоон шөнө сэрээлээ" гэсэн нь ямар далд утга санааг илэрхийлсэн бэ?

- A. уйтгар гунигт автаад байх
- B. нойр хүрэхгүй сэрвэлзээд байх
- C. сэтгэл үймрэн шимшрээд байх
- D. санаа сэтгэл тогтохгүй байх
- E. сэтгэл зүрх догдлоод байх

10. Сонсох, амтлах, харах мэдрэмжийг илэрхийлсэн уран дүрслэлийг олоорой.

- A. шувуу адил нисэх, алтан аягаар зооглох, огторгуйн будан хөглөрөх
- B. шуугианд чих дөжрөх, атга будаа шүтэх, хорвоогоор нэг тарах
- C. шувуу адил нисэх, мөнгөн царанд таваглах, шуурга болж туйлах
- D. сонор шүргээд буцах, бэлэн тансгийг эрэх, огторгуйн будан хөглөрөх
- E. сонор шүргээд буцах, алтан аягаар зооглох, огторгуйн будан хөглөрөх

11. "Амраг нэгний санаашрал **сонор** шүргээд буцах" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг "дэлдгэр" хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?

- A. Доод найруулгын зэрэгтэй болно.
- B. Хүндэтгэлийн утгатай болно.
- C. Найруулгад өөрчлөлт орохгүй.
- D. Дээд найруулгын зэрэг хэвээр.
- E. Найруулгын өрийн зэрэгтэй болно.

12. Онцолсон гишүүн өгүүлбэрийн утгын уялдааг тодорхойлоорой.

Хүний нутгийн шуугианд чих дөжирч явахдаа өөрийн нутгийн заримтай мэнд сольж амжлаа.

- A. "мэнд" гэсэн үгтэй дүр байдлын утгаар холбогдсон.
- B. "нутаг" гэсэн үгтэй орны утгаар холбогдсон.
- C. "амжлаа" гэсэн үгтэй шалтгааны утгаар холбогдсон.
- D. "сольж" гэсэн үгтэй цагийн утгаар холбогдсон.
- E. "заримтай" гэсэн үгтэй зорилгын утгаар холбогдсон.

13. "Хээрийн цэцэгсээр энгэрээ гоёх" гэсэн өгүүлбэрийг тонгоргон хувиргасныг олоорой.

- A. Хээрийн цэцэгсээр энгэрээ чимэх
- B. Энгэрээ гоёх
- C. Хээрийн гоё цэцэгсээр энгэрээ гоёх
- D. Талын цэцэгсээр энгэрээ гоёх
- E. Энгэрээ хээрийн цэцэгсээр гоёх

14. "Рашаан тунгалаг Туулаа аргагүй санах"-ын шалтгааныг илэрхийлсэн өгүүлбэрийг сонгоно уу.

- A. Ясаа тавих алга дарам газартай учраас
- B. Явган нүцгэн ч гэлээ очоод жаргах оромж бий учраас
- C. Нутгаа гэсэн төрөлх араншин сэтгэлд оршдог учраас
- D. Хүний газрын шуугианд чих дөжирсөн учраас
- E. Аяс намрын салхи нутаг зүгээс дуудсан учраас

15. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.

- A. Олны дунд нэр төрөө эрхэмлэж яваарай, хүү минь.
- B. Манай ангийн охидууд сагсан бөмбөгийн тэмцээнд түрүүлэв.
- C. Монголчууд эртнээс нааш галаа тахиж ирсэн заншилтай.
- D. Сурагчдадаа эрүүл амьдрахуйн талаар зөвлөв.
- E. Олимпод оролцох тамирчид бэлтгэлдээ гарчээ.

16. Холбоо үгсийн бүтсэн аргын зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг олно уу.

эрэл сурал, цанын бааз, уншиж бичих,

- A. өгсөж уруудах
- B. хөхөө шувуу
- C. эрт урьд
- D. ойн чөлөө
- E. дуу хөгжим

17. Дагалдах утгат бүтээврийг сонгоорой.

- A. -могц
- B. -нүүт
- C. -вч
- D. -нгоо
- E. -хлоор

18. Нутгийн аялгууны үгийг олоорой.

- A. зах зээл
- B. интернэт
- C. тоохуу
- D. банш
- E. ЮНЕСКО

19. "Хэдэн залуус морь тарлаж, нутгийн өвгөд уяа сойлгыг шинжинэ" өгүүлбэрийн онцолсон бүтээврийг солин найруулахад аль нь тохирох вэ?

- A. -вч
- B. -н
- C. -магц
- D. -тал
- E. -х

20. Тайлбарыг жишээтэй зөв харгалзуулсныг сонгоно уу.

- 1. туул a. эцэс хязгаар
- 2. тууль b. ус гол гатал
- 3. туйл c. аман зохиол
- A. 1a, 2b, 3c B. 1a, 2c, 3b C. 1c, 2a, 3b
- D. 1b, 2c, 3a E. 1b, 2a, 3c

21. Эсрэг утгат бүтээвэр бүхий хэсгийг сонгоорой.

- A. нимгэн + л, нимгэн + д
- B. тохь + той, тохь + гүй
- C. танай + хан, танай + х
- D. гэд + лз, гэд + ий
- E. ус + чин, ус + ч

22. "Гагнасан гинжийг таслагтун" өгүүлбэрийн онцолсон үгийн язгуурыг олоорой.

- A. гаг
- B. гагна
- C. ганна
- D. ган
- E. гагнуур

23. Залгавар залгахад "ь" нь "и" болохгүй үгийг олно уу.

- A. сахь + ж
- B. барь + жээ
- C. соль + могц
- D. зохь + дог
- E. холь + оо

24. Дараах өгүүлбэрт таслал хэрэглэсэн шалтгааныг сонгоорой.

Түүний онигор нүд, монхор хамар, урт туушин, уужим магнай, навчин чих, нарийн бүсэлхий, түхгэр цээж, урт гар, өргөн аарцаг, уудам салтаа, том тавхай нь яах аргагүй сайн бөхийн арван шинж бүрдсэний гэрч ажээ.

- A. Тоочсон олон зүйлсийг утгаар зүйлчлэн ялгасан тул
- B. Нийлмэл өгүүлбэр тул
- C. Оруулсан үг тул
- D. Санаа бүрэн төгсөөгүй тул
- E. Тоочсон үгсийн хооронд тул



25. Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгийн онцолсон хэсгийн хам сэдвийг олоорой.

...Сүлжилдэн давхих хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь миний сэтгэлийг даруй бахдуулж, Сан бэйсийн морины сайхан нь миний дурыг хөвсөлзүүлэн хөдөлгөнө. Монгол газар уудам юм аа.

Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмсөн, зүүн ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган, жолоо цулбуурыг хугас барин атгаад, баруун ханцуйгаа сул тавин, түүний дотор гараа нуун, ташаагаа тулж буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ. ...Хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээхүй нь хаврын улирал ирж буй адил бахтай.

- A. түүхийн B. нийгмийн C. шашны D. соёлын E. улс төрийн

26. Дээрх /сорил-25/ хэсгийн үйл явдал хэдий үед өрнөж байна вэ?

- A. XX зууны эхэн үе B. XV зууны үе C. XX зууны дунд үе
D. XX зууны сүүл үе E. XXI зууны эхэн үе

27. Дээрх /сорил-25/ зохиолын хэсэгт “...инээмсэглэн мишээхүй нь хаврын улирал ирж буй адил бахтай” гэсэнд дүрслэлийн ямар ур маяг илэрсэн бэ?

- A. юмшуулал B. өгөөдөл C. төлөөлөл
D. ихэсгэл E. адилтгал

28. “Хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээхүй нь хаврын улирал ирж буй адил бахтай” /сорил-25/ хэсэгт дүрийн ямар зан байдлыг харуулсан бэ?

- A. ичимхий даруу B. хөнгөн хийсвэр C. аальгүй маягтай
D. баяр баясгалантай E. эгэл боргил

29. Б. Лхагвасүрэнгийн “Боржигины бор тал” шүлгийн дараах 4 шадын толгой холбоц аль вэ?

Таанын цагаан толгойноос өөр
Тайтгаруулах цэцэггүй нүцгэн тал минь
Нандин эрхэмсэг эгэл боргилын туйл
Нар хур царайчилсан газрын саальтай хормой минь...

- A. АБАБ B. АААБ C. АББА
D. АААА E. ААББ

30. Дээрх /сорил-29/ хэсэгт үзүүлсэн гадаад орчныг сонгоорой.

- A. цайдам хөндий B. овоот хөтөл C. баян бүрд
D. уулын зоо E. голын бэлчир

31. Уншихдаа онцолсон үгсийн бичлэгийг ажиглаад, бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.

- A. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$
- B. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$
- C. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$
- D. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$
- E. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$

32. Уншаад хэлцийн утгыг олно уу.

- $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ A. гярхай B. шударга C. ирээдүй D. хурдан E. сэргэлэн


33. “хадлангийнхаа” гэсэн үгийг зөв бичсэнийг олно уу.

- A. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ B. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ C. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ D. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ E. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$






34. Галигийг зөв бичсэн хэсгийг сонгоно уу.
Тэгхэ-ийн жим-ийэр бэдэрихү

- A. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ B. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ C. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ D. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$ E. $\begin{matrix} \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \\ \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} & \text{ᠠᠨᠢᠨᠢᠨ} \end{matrix}$






35. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- | | | | | |
|--|--|--|--|--|
| A.  | B.  | C.  | D.  | E.  |
|--|--|--|--|--|






36. "Би" гэсэн үгийг эзэнд хамаатуулах нөхцөлтэй өгөх оршихын тийн ялгалаар хувилгасан нь аль вэ?

- | | | | | |
|--|--|--|--|--|
| A.  | B.  | C.  | D.  | E.  |
|--|--|--|--|--|






37. Бусдаар үйлдүүлэх хэвийн -гэ дагавартай үгийг сонгоно уу.

- | | | | | |
|--|--|--|--|--|
| A.  | B.  | C.  | D.  | E.  |
|--|--|--|--|--|


38. "унш" гэсэн үгийг биеэр төгсгөвөл аль нөхцөлийг залгах вэ?

- | | | | | |
|---|---|---|---|---|
| A.  | B.  | C.  | D.  | E.  |
|---|---|---|---|---|

39. "усны олом, эмээлийн олом"-ыг утга ялгасан хэсгийг олоорой.

- | | | | | |
|--|--|--|--|---|
| A.  | B.  | C.  | D.  | E.  |
|--|--|--|--|---|

40. Зөвийг сонгоно уу.

- | | | | | | |
|---|-------------|------------|---------------|-------------|----------------|
|  | A. лаборант | B. либерал | C. лаборатори | D. логарифм | E. Лихтенштейн |
|---|-------------|------------|---------------|-------------|----------------|

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

Жич: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------------------|--|
| a. Тос царцав. | 1. гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| b. Дорж хэлсэн. | 2. харьяалахын тодотгол гишүүнтэй цөм бус өгүүлбэр |
| c. Хүзүүний зүүлт авав. | 3. хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| d. Гурвалжин дүрс зурлаа. | 4. нэрийн тодотгол гишүүнтэй цөм бус өгүүлбэр |
| e. Үдийн үед хөдөлцгөөнө. | 5. байц гишүүнтэй цөм бус өгүүлбэр |






2.2. Холбох үг, нөхцөлийг харгалзуулна уу.

- | | |
|------------|--|
| a. -вөл | 1. цагийн утгат угсруулан холбох үг |
| b. үес | 2. шалтгааны утгат угсруулан холбох үг |
| c. тулд | 3. угсруулан холбох нөхцөл |
| d. - ч | 4. зэрэгцүүлэн холбох үг |
| e. хийгээд | 5. зэрэгцүүлэн холбох нөхцөл |

2.3. Бүтээврийн нийлцийг тохирох дүрэмд харгалзуулаарай.

- | | |
|-------------------|---|
| a. бахархал + ын | 1. Эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй. |
| b. олбор + оос | 2. Зөөлрүүлэх үүрэгтэй эгшгийг гээхгүй. |
| c. үзэгдсэн + ийг | 3. Заримдаг гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй. |
| d. тусгал + аар | 4. Балархай эгшиг үүрэггүй болсон тул гээнэ. |
| e. сорил + оор | 5. Ялгах үүрэгтэй эгшгийг гээхгүй. |

2.4. Үгсийг тохирох утгатай нь харгалзуулна уу.

- | | | | | | |
|-------------------|--|--|--|--|--|
| a. дэвлэ /дэвэх/ | 1.  | 2.  | 3.  | 4.  | 5.  |
| b. тээл /даваа/ | | | | | |
| c. тэвэр /үйл үг/ | | | | | |
| d. давла /бялхах/ | | | | | |
| e. дээл /хувцас/ | | | | | |

№	B		C	
	ХУВИЛБАР		ХУВИЛБАР	
	Зөв хариу	Оноо	Зөв хариу	Оноо
1	A	2	A	2
2	C	2	C	2
3	D	2	B	2
4	E	2	D	2
5	B	2	E	2
6	B	2	D	2
7	B	2	B	2
8	D	2	D	2
9	E	2	B	2
10	A	2	E	2
11	A	2	A	2
12	E	2	D	2
13	E	2	E	2
14	C	2	C	2
15	C	2	B	2
16	D	2	D	2
17	D	2	E	2
18	B	2	C	2
19	B	2	B	2
20	D	2	D	2
21	E	2	B	2
22	B	2	D	2
23	D	2	B	2
24	E	2	E	2
25	D	2	D	2
26	B	2	A	2
27	E	2	E	2
28	A	2	D	2
29	B	2	E	2
30	C	2	A	2

31	D	2	C	2
32	E	2	D	2
33	E	2	B	2
34	C	2	D	2
35	D	2	E	2
36	B	2	A	2
37	A	2	D	2
38	D	2	C	2
39	C	2	B	2
40	E	2	D	2
2.1	a4	1	a3	1
	b5	1	b1	1
	c3	1	c2	1
	d1	1	d4	1
	e2	1	e5	1
2.2	a5	1	a3	1
	b4	1	b1	1
	c2	1	c2	1
	d3	1	d5	1
2.3	e1	1	e4	1
	a5	1	a4	1
	b3	1	b1	1
	c4	1	c3	1
2.4	d1	1	d5	1
	e2	1	e2	1
	a4	1	a4	1
	b1	1	b3	1
	c2	1	c5	1
2.4	d5	1	d1	1
	e3	1	e2	1